

Хэрэв та Гепатит В-тэй жирэмсэн бол хүүхдээ болон өөрийн эрүүл мэндийг хэрхэн хамгаалах вэ



Гепатит В бол хүүхэд тань насан туршдаа тээж болохуйц ноцтой өвчин юм. Хэрэв та жирэмсэн бөгөөд гепатит В-тэй бол вирус төрөх үеийн цустай хүрэлцэх замаар шинэ төрсөн хүүхдэд халдварлаж болно. Хүүхдэдээ халдахаас сэргийлэх, өөрийгөө эрүүл байлгахын тулд жирэмсэн байх үедээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ уулзаж, тэдэнтэй гепатит В-ийн тухай ярилцаарай.

Энэ хүснэгтийг ашиглан өөрийн асаргаа, хүүхдийн асаргааг жирэмсэн байх үед болон дараа нь хянаарай!

Ээжийн хувьд

Жирэмсний явцад

- ✓ Гепатит В вирусн түвшин болон элэгний үйл ажиллагаагаа шалгахын тулд жирэмсний эхэн үед эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ гепатит В-ын талаар уулзаарай.
- Хэрэв шаардлагатай бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч тань гепатит В-ийн эм бичиж өгөх болно.

Төрөх үед

- ✓ Эмнэлэг дэх ажилтнууд таныг гепатит В-тэйг мэдэж байх ёстой.
- ✓ Хүүхдийг тань асран эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч таныг гепатит В-тэйг мэдэж байх ёстой.

Төрсний дараа болон цаашид

- ✓ Хүүхэд 1-2 сартайд гепатит В-ийн асаргааны талаар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ уулзаарай.
 - ТЖирэмсэн байх явцад эмчилгээ эхэлсэн бол энэ нь ялангуяа чухал юм.
- ✓ Доод тал нь 6 сар тутамд гепатит В-ийн мониторинг хийлгэж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ уулзаарай.



Жирэмсэн үедээ хамтрагч болон тантай хамт амьдардаг хүмүүсээ гепатит В-ийн шинжилгээнд хамруулж, вакцин хийлгээрэй.

Хүүхдийн хувьд

Төрөх үед

- Хүүхэд тань төрснөөс хойш 12 цагийн дотор халдвараас хамгаалж 2 тарилга хийлгэх ёстой:
- ✓ Гепатит В-ийн дархлааны глобулины (HBIG) ганц тун
 - ✓ Гепатит В-ийн вакцины 1-р тун

1-2 сартайд

- ✓ Хүүхэд тань гепатит В-ийн вакцины 2-р тунг хийлгэх цаг болжээ.

6 сартайд

- ✓ Хүүхэд тань гепатит В-ийн вакцины 3-р тунг хийлгэх цаг болжээ.

9-12 сартайд

- ✓ Хүүхдийн тань гепатит В-ийн төлөв байдал, хамгаалалтын түвшинг үнэлэхийн тулд хүүхэд тань цусны шинжилгээ хийлгэх шаардлагатай.

Хөхөөр хооллолт

- ✓ Хөхөөр хооллох тухай дэмжлэг авах, хагарсан эсвэл цус гарч байгаа хөхний толгойноос хэрхэн сэргийлэх, хүүхэд цустай хүрэлцэхийг багасгахын тулд хэрхэх тухайд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцаарай.
- ✓ Хэрэв таны шинэ төрсөн хүүхэд гепатит В-ийн вакцин болон дархлааны глобулины (HBIG) тунг төрөх үедээ хийлгэсэн бол хөхөөр хооллох замаар эхээс хүүхдэд гепатит В халдварлах эрсдэл маш бага байдаг. Хүүхэд тань эдгээр тунг хийлгэсэн бол хөхөөр хооллоход аюулгүй.